



**ТӨВ АЙМАГ**

**2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАРАА,  
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДАН  
АВАЛТЫН ТАЙЛАН**

Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам маягт 2-9”

**2021.01.10**

## Агуулга

### Ерөнхий зүйл

#### **Нэг. Төв аймгийн 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:**

- 1.1. Төв аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр тоо баримт, биелэлтийн хувиар.
- 1.2. 2020 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэл болон хэрэгжилтийн мэдээлэл.
- 1.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа.
- 1.4. Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн эсэх тухай.
- 1.5. Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн засаж залруулсан тухай.
- 1.6. Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн тухай.
- 1.7. Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн тухай.

#### **Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан талаар**

- 2.1. Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон систем ашиглалтын байдал.
- 2.2. Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн байдал.

#### **Гурав. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар.**

- 3.1. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан байдал.

**Дөрөв. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаарх дүгнэлт, санал**

- 4.1. Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлт.
- 4.2. Гэрээний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж ажилласан байдал.
- 4.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цаашид улам үр дүнтэй болгох санал, зөвлөмж, хүсэлт.

\*\*\*\*\*

## Ерөнхий зүйл:

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган гарсан журам эрх зүйн актууд болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолыг үндэслэн 2020 онд аймагт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийг батлуулсан.

Дээрхи тогтоолыг шийдвэрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/629 дугаар захирамжын 1 дүгээр хавсралтаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлаж, 2 дугаар хавсралтаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэх ажилд хяналт тавьж ажиллах үүрэг бүхий захиалагч байгууллагуудыг томилон ажиллуулсан.

Худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйл, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
[2021.01.10]



Д. МӨНХБААТАР

## Нэг. Аймгийн 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт

---

### 1.1. Төв аймгийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт санхүүжилтийн эх үүсвэр бүрээр тоо баримт, биелэлтийн хувиар:

#### 2020 онд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авахаар тусгагдсан нийт ажлын ерөнхий мэдээлэл:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолыг үндэслэж аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/629 дүгээр захирамжаар 13 481.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 9 900.8 сая төгрөгийн 74 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр;
2. Худалдан авах ажиллагааны нэмэлт төлөвлөгөөг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яамдаас эрх шилжүүлсэн 26 төсөл, арга хэмжээ аймгийн ИТХ-ын 2019 оны 15 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 1 төсөл, арга хэмжээний нийт 25 378.6 сая төгрөгийн ажлыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/93 дугаар захирамжаар;
3. Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/155 дугаар захирамжаар “Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны нэмэлт төлөвлөгөө батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/118 дугаар тушаал, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 53 дугаар тушаалаар сайдын багцаас эрх шилжүүлж хэрэгжүүлэх 584.8 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгав;
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/193 дугаар тушаалаар эрх шилжүүлж хэрэгжүүлэх 15.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд нэмж төлөвлөсөн;

5. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 17 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/393 дугаар захирамжаар 185.7 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр;
6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 18 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг үндэслэж аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/504 дүгээр захирамжаар 186.9 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр;
7. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоол, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр нийт 585.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/565 дугаар захирамжаар тус тус 2020 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны нэмэлт төлөвлөгөөг баталсан.

Дээрх тогтоол, захирамжийн шийдвэрээр 2020 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 124 төсөл, арга хэмжээнд 40 511.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд үүнээс 2019 онд тендер шалгаруулалт зохион байгуулагдсан төсөл, арга хэмжээ, мөн 2020 онд гэрээ шууд байгуулж хэрэгжүүлэх 3 028.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 ажлын үлдэгдэл санхүүжилтэд 2 145.1 сая төгрөгийг олгохоор шийдвэрлэн баталсан.

**Нийт худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг олон нийтэд зарлан мэдээлсэн байдал:** “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн 48.5-д заасны дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг хуулийн хугацаанд багтаан аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) вэб сайт, Төв аймгийн [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn) сайт, [www.khural.mn](http://www.khural.mn) сайт, [www.umch.to.gov.mn](http://www.umch.to.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайт, өдөр тутмын “Монголын үнэн”-ны 2020.01.08-ны өдрийн №003 Зургаадугаар нүүрт, “Өдрийн сонин”-ны 2020.01.07-ны өдрийн мягмар гарагын №003(6369) дугаарт нийтлэн олон нийтэд мэдээлж ажилласан.

**Аймагт хэрэгжсэн худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр:** Төв аймагт улс, аймгийн төсвийн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сан, бусад төсвийн эх

үүсвэрүүдээр нийтдээ 40 511.5 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй 124 төсөл, арга хэмжээ 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаж 37 483.1 сая төгрөгийн 95 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт зохион байгуулахаар төлөвлөгдсөн. Тайлант онд дэлхий нийтийг хамарсан цар тахал буюу covid-19 гарч Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас эрх шилжүүлсэн засварын ажлын 2 846.6 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг covid-19-д зарцуулж ингэснээр **2020 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулах 34 636.5 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр болж, аймагт хэрэгжиж байгаа ажлын худалдан авах ажиллагааны явц тайлант оны жилийн эцэст 98.00 хувьтай байна.**

*Хүснэгт-1: Аймгийн ОНӨГХАААлбанд зохион байгуулагдах нийт ажлууд, санхүүжилтийн эх үүсвэрээр*

д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх ажлын тоо	Төсөвт өртөг (сая,төг)	2020 онд олгох санхүүжилт (сая,төг)
1	Улсын төсвийн хөрөнгөөр	25	23 328.3	7 554.8
2	Аймгийн ОНХөгжлийн сан	17	5 061.5	2 846.8
3	Аймгийн ОНЗамын Сан	7	528.0	519.7
4	Аймгийн БХНССан	9	568.9	568.9
5	Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл	23	4 582.1	3 466.7
6	Аймгийн ИТХ-н 2019 оны 15 дугаар хурлын 1 дүгэр тогтоол он дамжиж зарласан ажил	2	59.2	57.6
7	Засаг даргын нөөц сан	2	83.0	83.0
8	Хятад Ард Улсын “Энхтайван сан”-н хөрөнгө оруулалтаар	1	425.5	425.5
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>86</b>	<b>34 636.5</b>	<b>15 523.0</b>

**Тендер шалгаруулалт зохион байгуулах-Хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтийн байдал, санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр:**

**1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:**

- Аймгийн Засаг даргад 2020 онд БСШУСЯамнаас 15 төсөл, арга хэмжээний 13 472.0 сая төгрөг, ЗТХЯамнаас 1 төсөл, арга хэмжээний 6 576.9 сая төгрөг, ЭМЯамнаас 6 төсөл, арга хэмжээний 2 809.6 сая төгрөг, БХБЯамнаас 1 төсөл, арга хэмжээний 259.8 сая төгрөг, БОАЖЯамнаас 1 төсөл, арга хэмжээний 50.0 сая төгрөг, ОБГазраас 1 төсөл, арга хэмжээний 160.0 сая төгрөгийн нийт 23 328.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж, эрх шилжүүлсэн ажлуудын

худалдан авах ажиллагааг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системийн цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж ажилласан.

## 2. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар

- Аймгийн ОНХөгжлийн сангийн хөрөнгөөр 5 061.5 сая төгрөгийн 17 ажлын худалдан авах ажиллагааг 88.23 хувьтай хэрэгжүүлсэн.
- Аймгийн ОНЗамын сангийн хөрөнгөөр 528.0 сая төгрөгийн 7 ажлын ХАА-г 100 хувьтай зохион байгуулсан.
- Аймгийн Байгаль Хамгаалах сангийн хөрөнгөөр 568.9 сая төгрөгийн 9 ажлыг 100 хувьтай зохион байгуулсан.
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс 4 582.1 сая төгрөгийн 23 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд тендер шалгаруулалтыг 95.83 хувьтай зохион байгуулсан.
- Аймгийн ИТХ-н 2019 оны 15 дугаар хурлын 1 дүгээр тогтоолоор он дамжин хэрэгжих 59.2 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг 100 хувьтайгаар хэрэгжүүлсэн.
- Аймгийн Засаг даргын нөөц сангаа өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх 2 төсөл, арга хэмжээг 100 хувьтайгаар хэрэгжүүлсэн.
- Хятад Ард Улсын “Энхтайван сан”-н хөрөнгө оруулалтаар 1 төсөл, арга хэмжээний 425.5 сая төгрөгийн ажлын тендерийг 100 хувьтайгаар зохион байгуулсан.

**2019 онд тендер шалгаруулалт** нь зохион байгуулагдсан, 2020 онд шууд худалдан авах нийт 3 028.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2 145.1 сая төгрөг олгох ажлын худалдан авах ажиллагаа 92.5 хувьтай хэрэгжиж байна.

*Хүснэгт-2: ХАА-гаа зохион байгуулагдахгүй нийт ажлууд, санхүүжилтийн эх үүсвэрээр*

д/д	Тендер зарлагдахгүй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр	Баталсан шийдвэр	Санхүүжилт олгох хэлбэр	Төсөл, арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2019 онд олгох санхүүжилт
1	Аймгийн ОН Хөгжлийн сан	ОН	2020онд тендер зарласан болон	7	2 524.5	1 664.7
2	Аймгийн ОН Замын сан	ОН Замын сан	ИТХ-н 2019 оны 2, хөтөлбөрийн	3	91.0	91.0
3	Аймгийн БХСан	БХСан	дугаар орон нутгийн	10	174.2	174.2
4	Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл	төсвийн тогтоол	оролцоо, шууд худалдан авалт	9	238.6	215.2
<b>НИЙТ ДҮН</b>				<b>29</b>	<b>3 028.3</b>	<b>2 145.1</b>



## **1.2 2020 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэл болон хэрэгжилтийн мэдээлэл:**

2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2 төсөл, хөтөлбөрт тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системээр зохион явуулсан. Үүнээс:

- Япон Улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын тендерийг зохион явуулж Арь констракшн ХХКомпани шалгарч, гэрээт ажлын явц 100%-тай хэрэгжсэн.
- БХБЯамнаас 2020 оны 10 дугаар сарын 29-нд БХБЯ/202010213 “1, 3-р өргөх станцын насосны хүчин чадлыг нэмэгдүүлэх /Төв, Зуунмод/ эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулж Хурд монтаж ХХК шалгарч гэрээт ажлын явц 80%-тай хэрэгжиж байна.

## **1.3 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа:**

2020 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлуудаас дараах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй, мөн удаашралтай байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 303.4 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг эрх шилжүүлсэн БСШУССайдын 2020.05.05-ны 1а/2796 албан бичгийн дагуу тендер шалгаруулалт (Лүн сумын цэцэрлэгийн барилга засвар 40.0 сая, мөн соёлын төвийн цахилгааны засвар 15.0 сая, Эрдэнэ сумын сургуулийн хичээлийн байрны засвар 45.0 сая, Зуунмод сумын Унагалдай цэцэрлэгийн барилга засвар 90.0 сая, Сургуулийн Б барилгын засварын 80.0 сая, Баянжаргалан сумын уурын зуухны барилга, халаалтын тогоо засварлах 48.4 сая)-ыг коронавирус гарсантай холбоотой санхүүжилтэд зарцуулахаар МУЗГазрын шийдэр гарч тендерийг зогсоосон. Мөн Аргалант суманд Их хаадын шүтээн цогцолбор судлалын төвийн барилга барих 2 504.2 сая төгрөгийн ажлын ТЭЗҮ, зураг төсөв бэлэн болж, үнэлгээний хороог байгуулсан боловч Монгол Улсын Их Хурлын 2020

оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” тогтоол, төсвийн тодотголоор хасагдсан тул хэрэгжих боломжгүй болсон.

2. Аймгийн Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянцогт сумын сургуулийн дотуур байр, Өндөрширээт сумын сургууль, Цээл, Дэлгэрхаан сумдын цэцэрлэгийн барилгуудыг ариун цэврийн байгууламжтай болгох Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг ариун цэврийн байгууламжтай болгох 158.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарлахаар захиалагч байгууллагаас ажлын даалгаврыг 2020 оны 05 дугаар сарын 26-ны 275 дугаар албан бичгээр ирүүлж, аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/412 дугаар захирамжаар үнэлгээний хороог байгуулж, үнэлгээний хорооноос тендерийн баримт бичгийг боловсруулж захиалагчаар батлуулсан боловч аймгийн Засаг даргын орлогчын 2020 оны 07 дугаар сарын 30-ны 01/1149 албан бичгээр Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, Мобиком корпораци, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Роял кинг констракшн ХХК-тай 2017 онд хамтран ажиллах, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж хөдөө орон нутгийн сургуулийн сурагчдын сурах, амьдрах орчин нөхцлийг сайжруулахад чиглэгдсэн “Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж” төслийг хүрээнд Роял кинг констракшн ХХК-тай гэрээ шууд байгуулах чиглэлийг захиалагч байгууллагад өгч тендер шалгаруулалт зарлагдаагүй, захиалагчийн зүгээс төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагын оролцооны хөрөнгө шийдвэрлэгдээгүй тул гэрээг тус компанитай байгуулаагүй, 2020 онд хэрэгжих боломжгүй болсон.
3. Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх “Цөлжилтийг сааруулах ажлын хүрээнд бэлчээрийн хортонтой тэмцэх ажлыг тал хээрийн сумдад 50.0 мянган га-д зохион байгуулах зардал” батлагдсан төсөвт өртөг 100.0 сая төгрөг, тендер шалгаруулалтыг 2020 оны 02 дугаар сарын 06-нд үнэлгээний хороог байгуулж, тендерийг 2020 оны 03 дугаар сарын 04-нд зарласан боловч аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/147 дугаар захирамжаар сумдад эрх


шилжүүлэн ажил гүйцэтгэх шийдвэр гарч тендерийг зогсоосон. Эрх шилжүүлсэн ажлын хөрөнгийг 14 суманд хуваарилж ажлын хэрэгжилтийг 100 хувь хангасан. /Уг ажил тендер зарлах ажил байсан/

4. Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх Туул, Хэрлэн голуудын дагуу загас үржүүлэх, жимсний модны бут сөөг тарих үржүүлгийн газар байгуулах төслийн ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээний 28.3 сая төгрөгийн ажлын тендерийг 2 удаа зохион байгуулж, тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул гэрээ шууд байгуулахаар үнэлгээний хорооны дүгнэлт гарч хууль, журмын дагуу гэрээ шууд байгуулах аргаар тендерийг зохион явуулсан боловч сонирхогч этгээдүүд оролцоогүй. Захиалагч байгууллагаас батлуулсан санхүүжилт нь уг зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсөвт багтахгүй, төсвийн төлөвлөлт бүрэн хийгдээгүй тул хэрэгжих боломжгүй болсон.
5. Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх хөндөгдсөн эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэн, эзэнгүй орхигдсон талбайгаас 10га-д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх 73.6 сая төгрөгийн ажлыг 2 удаа нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарлаж, шалгаруулалт амжилтгүй болж гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан боловч оролцогч оролцоогүй 2020 онд хэрэгжээгүй.

#### **1.4 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн эсэх тухай:**

Тайлант оны жилийн эцсийн байдлаар 5 төсөл, арга хэмжээ (улсын төсвийн **хөрөнгө оруулалтаас:** Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай авто зам 7км /Төв, Зуунмод/, соёлын төвийн барилгын их засвар /Төв, Сүмбэр сум/, соёл, спортын төвийн барилга угсралт /Төв, Борнуур сум/, **аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаас:** аймгийн хэмжээнд 26 суманд бэлчээрийн худаг шинээр гаргах ажил, сумдад бэлчээрийн худаг гаргах 13 сум)-ний тендерийн хүчинтэй хугацааг Сангийн яаманд хандаж сунгуулсан. **Тендерийн үнэлгээний дундаж хугацаа:** Тендер шалгаруулалтыг тендер нээснээс хойш хүчинтэй хугацаа хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт зааснаар 30 хоног байх бөгөөд аймгийн хэмжээнд тендерийг үнэлэх дундаж хугацаа 21 хоног байна.

График: Аймгийн худалдан авах ажиллагааны газарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн тендерийн дундаж хугацаа



### 1.5. Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн засаж залруулсан тухай:

Тендер шалгаруулалтыг зохион явуулах болон хяналт, шалгалтын байгууллагаас өгч буй зөвлөмж, дүгнэлтэд дурдагдсан алдаа дутагдлыг засах чиглэлээр төсөл, арга хэмжээ бүрт байгуулагдсан үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, хөндлөнгийн төлөөлөгч нарт тендерийн баримт бичгийг боловсруулахдаа батлагдсан хууль, журамд нийцүүлэх, тендер шалгаруулалтын үнэлгээг ТБОНӨХБАҮХАТХуулийн 27, 28 дугаар зүйлд заасны дагуу тендер шалгаруулалтын өгөгдөлд заасан шалгуур, үзүүлэлтийг хангасан хуулийн этгээдийг шалгаруулах талаар тухай бүрд зөвлөгөө, үүрэг, чиглэл өгч ажилласан. Мөн захиалагч байгууллагаас баталж ирүүлсэн ажлын зураг, төсөв, тоо хэмжээнд 1-2 удаа тодруулга гаргах зэрэг зөрчлүүд гарч байсан бөгөөд түүнийг тухай бүрд нь залруулж, захиалагчаар томилогдсон байгууллага болох аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГазарт анхааруулж, төсөл арга хэмжээг хариуцан ажилласан үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарт зөвлөгөө өгч ажилласан.

### 1.6. Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн тухай:

Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам” батлагдаж журмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2020 онд зарлагдсан цахим тендер шалгаруулалтын явц, үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системд нийтлэж ажилласны үр дүнд тендерт оролцогчдоос тайлан онд 8 төсөл, арга хэмжээнд оролцогч 8 аж ахуйн нэгжээс захиалагчийн шийдвэрийг хянаж, шалгуулахаар Сангийн яаманд, 1

төсөл, арга хэмжээнд захиалагч байгууллагад тендерт оролцогч гомдол гаргасан байна.

Үүнд:

1. Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай авто зам, 7.0км /Төв, Зуунмод сум/ ЗТХЯ/202002006 дугаартай 6 576.9 сая төгрөгийн төсөвтэй ажлын цахим тендерт оролцогч “ЗЗБ” ХХКомпани 2020 оны 05 дугаар сарын 06-нд Сангийн яаманд гомдол гаргаж, гомдол хянан шийдвэрлэгчийн 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр гомдолд дурдсан зарим асуудлаар захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байх тул дээрх тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлж дахин хийхийг ТБОНӨХБАҮХАТХуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3-т заасны дагуу мэдэгдсэн байна. Үнэлгээний хорооноос Сангийн яамны албан мэдэгдлийн дагуу дахин үнэлгээ хийж шаардлага хангасан оролцогч байхгүй гэж үзэж дахин нээлттэй тендер зарлахаар шийдвэрлэсэн.
2. Соёлын төвийн барилгын их засвар /Төв, Сүмбэр сум/ 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй БСШУСЯ/202001170 дугаартай тендер шалгаруулалтад Некстстандарт ХХК 2020 оны 05 дугаар сарын 15-нд Сангийн яаманд гомдол гаргаж, тус яамны 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гомдолд дурдсан зарим асуудлаар захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байх тул дээрх тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлж дахин хийхийг ТБОНӨХБАҮХАТХуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3-т заасны дагуу мэдэгдсэн байна. Үнэлгээний хорооноос Сангийн яамны албан мэдэгдлийн дагуу дахин үнэлгээ хийж шаардлага хангасан оролцогч байхгүй гэж үзэн ТБОНӨХБАҮХАТХуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.1-т зааснаар дахин нээлттэй тендер зарласан.
3. Сумдад бэлчээрийн худаг гаргах 13 сум ТӨАОНӨГ/202012038 дугаартай 156.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт оролцогч Голденхилл ХХКомпани 2020 оны 05 дугаар сарын 19-нд Сангийн яаманд гомдол гаргасан байна. Сангийн яамны 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр гомдол хянасан тухай хариуг ирүүлэхэд захиалагчийн гаргасан 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 232 дугаар гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтад заасны дагуу хүчингүй болгож тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлж дахин үнэлгээ хийхийг мэдэгдсэний дагуу дахин үнэлгээг хийж Эрдэнэдриллинг ХХКомпанийг шаардлагад нийцсэн

тендер ирүүлсэн гэж үзэн шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд дахин гомдол гараагүй.

4. Аймгийн хэмжээнд 26 сумын бэлчээрийн худаг шинээр гаргах 312.0 сая төгрөгийн өртөгтэй ТӨАОНӨГ/202012008 дугаартай цахим тендерийн багц1-т Голденхилл ХХК гомдол гаргаж Сангийн яамны 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр гомдол хянасан тухай хариуг ирүүлэхэд захиалагчийн гаргасан 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 229 дүгээр гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтад заасны дагуу хүчингүй болгож тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлж дахин үнэлгээ хийхийг мэдэгдсэний дагуу дахин үнэлгээ хийж Голденхилл ХХКомпанийг шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн гэж үзэн шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд дахин гомдол гараагүй.
5. 10 ортой эрүүл мэндийн төвийн барилга барих /Төв, Баян-Өнжүүл сум/ ТӨАОНӨГ/202012004 дугаартай 1 000.0 сая төгрөгийн өртөгтэй цахим тендер оролцогч Ий Би Си ХХКомпани 2020 оны 03 дугаар сарын 17-нд Сангийн яаманд гомдол гаргаж, гомдлыг хянасан байгууллагаас тус тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна гэж дүгнэсэн тул үнэлгээний хороо дахин нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан.
6. ЗДТГ-ын барилга шинээр барих /Төв, Бүрэн сум/ 970.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТӨАОНӨГ/202012053 дугаартай цахим тендер 2020 оны 05 дугаар сарын 26-нд оролцогч Мета менежмент ХХКомпани Сангийн яаманд гомдол гаргаж, гомдлыг хянасан эрх бүхий байгууллагаас 2020 оны 06 дугаар сарын 08-нд тус тендер шалгаруулалтад оролцогч Хөлөг-Од ХХК, Мета менежмент ХХК нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дах хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тул захиалагчийн гаргасан 2020 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 250 дугаар гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтад үндэслэн хүчингүй болгож тендер шалгаруулалтыг хуульд нийцүүлэн дахин зохион байгуулахыг мэдэгдсэн байна. Тус ажлын үнэлгээний хороо Сангийн яамнаас ирүүлсэн шийдвэрт Мета менежмент ХХКомпаний татгалзсан үндэслэлийг дурдаагүй, хүчингүй болгосон бөгөөд үнэлгээний хороо хэлэлцэж Мета менежмент ХХКомпанийг шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулж ажилласан байна.

7. Орон нутгийн авто замын тэмдэг, тэмдэглэгээ худалдан авах ТӨАОНӨГ/202012023 дугаартай 50.0 сая төгрөгийн ажилд Авто замын гэрлэн дохио ХХКомпаниа 2020 оны 03 дугаар сарын 31-нд Сангийн яаманд гомдол гаргаж, Сангийн яамны 2020 оны 04 дүгээр сарын 10-ны 6-1/2307 дугаар албан бичгээр гомдлыг хянаж захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байх тул тендер шалгаруулалтыг цааш үргэлжлүүлэхийг мэдэгдсэн бөгөөд гэрээ үнэлгээний хорооны 3 дугаар хурлын шийдвэрийн дүгнэлтээр шалгарсан Глобалдизайн ХХК-тай гэрээг байгуулж ажилласан.
8. Авто замын их засвар хийх /Төв, Борнуур сум/ 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт оролцогч Сейф транс ХХКомпаниас Сангийн яам гомдол гаргасан бөгөөд гомдол үндэслэлтэй тул дахин үнэлгээ хийхийг мэдэгдсэн тул үнэлгээний хороо хууль, журмын дагуу дахин үнэлгээ хийж тендерийг харьцуулалтын аргаар дахин цахим тендер зохион байгуулж ажилласан.
9. Соёл, спортын төвийн барилга угсралтын /Төв, Борнуур сум/ 2 000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт оролцогч Жоншт ХХКомпаниас захиалагч байгууллага болох аймгийн Барилга, захиалагч орон сууцны корпораци орон нутгийн өмчит аж ахуйн газарт гомдол гаргаж, захиалагчийн шийдвэрээр үнэлгээний хороо тендерийн үнэлгээг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй гэж үзэж гомдол гаргагчийн тендерт оролцсон материалыг үнэлгээний хороонд хүргүүлж хууль, журмын дагуу шийдвэр гаргуулж ажилласан байна.
10. ТӨАОНӨГ/202012017 дугаартай “Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт хяналтын монитор нийлүүлэх” 120.0 сая төгрөгийн ажилд 2020 оны 03 дугаар сарын 19-нд Мед буян ХХКомпани Сангийн яаманд гомдол гаргасан. Сангийн яамны 2020 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 6-1/2013 дугаартай албан бичгээр дахин үнэлгээ хийх үүрэг өгсөний дагуу үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж Мед буян ХХКомпанийг шалгаруулсан боловч уг тендерт оролцогч Ивээлт гүн ХХкомпаниас 2020 оны 04 дүгээр сарын 17-нд Сангийн яаманд гомдол гаргаж, гомдол хянасан тухай 2020 оны 04 дүгээр сарын 28-ны 6-1/2798 дугаартай албан бичгээр дахин үнэлгээ хийх үүрэг өгч үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж ажилласан байна.

2020 онд зарласан цахим тендер шалгаруулалтад оролцогчдоос Сангийн яам болон захиалагч байгууллагад гаргасан нийт 10 ажлын тендерт оролцсон 11 оролцогчтой холбогдох гомдол шийдвэрлэлтийг авч үзвэл үнэлгээний хорооноос гаргасан 1 ажлын гомдол хууль, журамд нийцсэн буюу захиалагчийн дүгнэлт үндэслэлтэй, 9 ажлын тендер шалгаруулалтын үнэлгээний хороо болон захиалагчийн дүгнэлт, шийдвэр хууль, журамд нийцээгүй буюу үндэслэлгүй тул дахин үнэлгээ хийх чиглэлийг Сангийн яамнаас үнэлгээний хороо болон захиалагч байгууллагад мэдэгдсэн.

### **1.7 Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн талаар тусгах:**

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба, сумын ЗДТГазар, төсөвт болон орон нутгийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газруудаас зарлаж буй цахим тендерийн баримт бичигт ТБОНӨХБАҮХАТХуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйл мөн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар (Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон) тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдох заалтыг тусгаж дотоодын худалдан авалтыг дэмжиж ажилласан. Үүнд:

1. Аймгийн түвшинд зарласан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерт шалгарсан 16 компани 1тэрбум 901.8 сая төгрөгийн дотоодын худалдан авалт хийсэн. (Хавсралт маягт 6-аас үзэх: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч)
2. Сумдын ЗДТГазраас зарласан төсөл, арга хэмжээний тендерт 9 хоршоо, 124 аж ахуйн нэгж, 37 өрхийн үйлдвэрлэгчээс нийт 1тэрбум 213.5 сая төгрөгийн дотоодын худалдан авалт хийсэн. (Хавсралт маягт 6-аас үзэх: Сумдын ЗДТГазар)
3. Төсөвт болон орон нутгийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газруудын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээнээс 19 аж ахуйн нэгж, 9 өрхийн үйлдвэрлэгчээс нийт 2тэрбум 123.4 сая төгрөгийн дотоодын худалдан авалт хийгдсэн байна. (Хавсралт маягт 6-аас үзэх: Төсөвт болон орон нутгийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар)



## **Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан талаар.**

### **2.1. Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалт тоо, хувь болон систем ашиглалтын байдал:**

Аймаг, сум болон төсөвт байгууллага, ОНӨААТҮГазруудад нийт 1357 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, шат шатны Төсвийн захирагч, төсвийн шууд захирагч нарийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн худалдан авах ажиллагааны цахим [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системд бүртгэн оруулж аймгийн хэмжээнд 100 хувь цахимд шилжүүлж, цахим тендер зарлаж тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд оруулан ажиллаж байна.

### **2.2. Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн байдал:**

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцэст худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээгээр аймгийн Эрүүл мэндийн газарт 16 нэр төрлийн 4 удаагийн захиалагаар 145.7 сая төгрөгийн гэрээг байгуулж ажилласан байна.

## **Гурав. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар:**

### **3.1. Тухайн төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан байдал:**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд 27 сумын ЗДТГазар, 12 агентлаг, 2 ОНӨААТҮГазрууд нийт 41 төсвийн шууд захирагчтай ажиллаж байна. Үүнээс аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төсөв нь батлагддаг 12 төсөвт байгууллагын мөн орон нутгийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн 2 газрын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж холбогдох хууль, журмын дагуу тендер шалгаруулалт зохион байгууллуулж хяналт тавьж ажилласан. 27 сумын ЗДТГазрын худалдан авах ажиллагаа хариуцан ажилладаг

мэргэжилтэн, үнэлгээний хорооны гишүүдэд мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

## **Дөрөв. Худалдан авах ажиллагааны талаарх дүгнэлт, санал:**

### **4.1. Төсвийн Ерөнхийлөн захирагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлт:**

#### **Аймагт хэрэгжсэн нийт худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр:**

- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулах 34 636.5 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, аймагт хэрэгжиж байгаа ажлын худалдан авах ажиллагааны явц тайлант оны жилийн эцэст 98.00 хувьтай байна.
- 27 сумдын Засаг даргын Тамгын газрын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 840 төсөл, арга хэмжээ төлөвлөгдөж үүнээс 9 982.4 сая төгрөгийн 235 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт зохион байгуулахаас тайлант оны жилийн эцэст 182 төсөл, арга хэмжээнд цахим тендер зарласан буюу төлөвлөгөөний хэрэгжилт 77.44 хувьтай байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт болон орон нутгийн төсөвт байгууллагын түвшинд 2020 онд 190 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 4 279.4 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээнд тендер зохион байгуулахаас 10 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж төлөвлөгөөний хэрэгжилтийг 55.55 хувьтай хангасан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагаанд төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт 98 хувьтай хангагдсан бол Төсөвт байгууллага болон сумдын түвшинд төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд урсгал зардлаас санхүүжүүлж хэрэгжүүлэх ажлын санхүүжилт *(Дэлхийн олон улс орон covid-19 цар тахал гарсантай холбоотойгоор хэрэгжилт бүрэн хангагдаагүй)*-ыг Монгол Улсын Засгийн Газрын шийдвэрээр төлөвлөгөөнд тусгагдаагүй нэмэлт зардалд зарцуулах, зарим төсөл, арга хэмжээний санхүүжилт огт хийгдээгүй байна.

### **4.2. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдал:**

Аймгийн Засаг даргын 2019 оны А/629 дугаар захирамжийн 2-р хавсралт, 2020 оны А/95, А/156, А/393, А/504, А/565 дугаар захирамжаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий захиалагчаар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ газар, Аймгийн Эрүүл мэндийн газар болон холбогдох төсөвт байгууллагуудыг томилж гэрээний гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллуулж байна.

#### **4.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цаашид улам үр дүнтэй болгох санал, зөвлөмж, хүсэлт:**

##### **Төлөвлөлт:**

-Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн дагуу цахим тендер шалгаруулалт явуулахад эрх шилжүүлсэн ТЕЗ, бодлогын газрууд системээр шилжүүлэх эрхийг шийдвэр гарсан даруй шилжүүлж ажиллах.

##### **Хэрэгжилт:**

-Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад төрийн байгууллагуудаас гардаг тодорхойлолт лавлагаа мэдээллийг авах нэгдсэн зохицуулалтаар тендерт оролцогчдоос шаардахгүй байх цахим худалдан авах ажиллагааны цахим системийг өргөжүүлэх шаардлагатай.

-тендер шалгаруулалтын үнэлгээг хүний оролцоогүйгээр цахимаар 100 хувь хийдэг болгох.

##### **Тайлагналт:**

-Төрийн худалдан авах ажиллагааны цахим [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системийн тайлагналын цэсийг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан тайлагнах маягтад шууд татагддаг болгох ингэснээр мэдээллийн зөрүүтэй байдал үүсэхээс сэргийлэх төдийгүй давхцсан ажил гүйцэтгэх байдал арилах юм.

\*\*\*\*\*

1. **ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН 15 ДУГААР ХУРАЛДААНЫ 02 ДУГААР ТОГТООЛ “АЙМГИЙН 2020 ОНЫ ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ”**
  - 1.1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2019 ОНЫ А/629 ДҮГЭЭР ЗАХИРАМЖ “ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
2. **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ТУШААЛ, ШИЙДВЭР, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ГАРГАСАН ЗАХИРАМЖ**
  - 2.1. МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2020 ОНЫ А/31 ДУГААР ТУШААЛ “ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ”
  - 2.2. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН 2020 ОНЫ А/56 ДУГААР ТУШААЛ “ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЧАНАРТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ”
  - 2.3. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН 2020 ОНЫ А/151 ДУГААР ТУШААЛ “ТУШААЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”
  - 2.4. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2020 ОНЫ А/73 ДУГААР ТУШААЛ “ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ”
  - 2.5. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 ОНЫ А/93 ДУГААР ЗАХИРАМЖ “ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ НЭМЭЛТ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
  - 2.6. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 ОНЫ А/95 ДУГААР ЗАХИРАМЖ “ЗАХИАЛАГЧ ТОМИЛОХ ТУХАЙ”
  - 2.7. МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН 2020 ОНЫ 53 ДУГААР ТУШААЛ “ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ”
  - 2.8. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2020 ОНЫ А/118 ДУГААР ТУШААЛ “ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ”
  - 2.9. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 ОНЫ А/155 ДУГААР ЗАХИРАМЖ “ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ НЭМЭЛТ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
  - 2.10. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 ОНЫ А/156 ДУГААР ЗАХИРАМЖ “ЗАХИАЛАГЧ ТОМИЛОХ ТУХАЙ”
  - 2.11. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН 2020 ОНЫ А/193 ДУГААР ТУШААЛ “ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”
  - 2.12. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 ОНЫ А/267 ДУГААР ЗАХИРАМЖ “ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ НЭМЭЛТ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗАХИАЛАГЧ ТОМИЛЖ БАТЛАХ ТУХАЙ”
  - 2.13. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 ОНЫ А/343 ДУГААР ЗАХИРАМЖ “ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ГЭРЭЭНИЙ ЗАСАГ  
ХУУЛЬ

2019 2 05 02

Аймгийн 2020 оны төсөв батлах  
тухай

Аймгийн 2020 оны төсвийн төсөв боловруулсан тухай аймгийн Засаг дарга /Ж.Батжаргал/-ын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын хэрэг, Төв аймаг дахь Гэрийн аудитын газраас хийсэн дүгнэлтүүдийн хэлэлцээл, "Төсвийн тухай" хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, Монгол Улсын Засаг захиргаа, ноутаг дэвсгэрийн нөхж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "б", 19 дүгээр зүйлийн 19.1 дэх мэдлүүд, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн 2020 оны төсөвт төвлөрүүлэх орлогог 17,586,000.0 мянган төгрөгөөр, нэр төрөл, хэмжээг дор дурдсангаар баталсугай:

Да	Орлогын нэр төрөл	Орлогын дүн /мянган төгрөг/
1.1.	<b>Аймгийн төсвийн татварын орлого</b>	<b>16,551,000.0</b>
1.1.2.	татварын төлбөр	1,740,000.0
1.1.3.	үз хөдлөх эд хөрөнгийн албан татвар	5,000,000.0
1.1.4.	авто бодон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	411,000.0
1.1.5.	үйлдвэр гэд үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	2,100,000.0
1.1.6.	хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлоготой ногдох албан татвар	8,000,000.0
1.1.7.	хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(950,000.0)
1.1.9.	улсын гэмдэгтийн хураамж	250,000.0
1.2.	<b>Аймгийн төсвийн татварын бус орлого</b>	<b>1,035,000.0</b>
1.2.1.	Хүү төртгүүлийн орлого	500,000.0
1.2.2.	Хөрөнгө барлуу асны орлого	200,000.0
1.2.3.	өрийн нутгийн өмчийн эд хөрөнгийн ашигласны төлбөр (гүрээ)	20,000.0
1.2.4.	хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого	300,000.0
1.2.5.	Төсөвт бичигүүдгүйн өөрийн орлого	15,000.0
	<b>Нийт дүн</b>	<b>17,586,000.0</b>

01.05.2

11. Энэ тогтоолыг сумандаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Төв аймаг дахь Төрийн аудитын газраас сумын төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийн талаар гаргасан санал дүгнэлтийн дагуу төхив тооцоо судалгаа мийж төсвийн орлогоо нэмэгдүүлэх арга хэмжээ авч, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд сумынхаа төсвийг батлан, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үйлдсүгэй.

12. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төргүүдэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА

ЦЭНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
 2020 оны 12 дугаар сарын 25 -ны  
 өдрийн 15 дугаар хуралдааны 02 дугаар  
 тогтоолын 1 дүгээр хавсралт

**АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ  
 ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

Д/а	Төсөл ярга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2020 оны санхүүжээ дүн
<b>1. ШИЛЖИХ БАРИЛГА:</b>				
1	Цэцэрлэгийн дээврийн их засвар /Зуулмод, Бүжигчин А,Б байр/	2019-2020	90,350	10,349.8
2	Газрын дуулаага худалдаагаар зарагдсан газруудад ээл бүтэц байгуулах зардал /Аймгийн төв, Зуулмош/	2019-2020	1,537,172	1,037,171.6
3	Гэр хороололыг дулам, цэвэр усан хангамжийн шугам бүлжээнд холбох /Төв, Зуулмод сум 2, 4, 5, 6-р баг/	2019-2020	1,267,056.5	610,000.0
4	10 ортой Эрүү мэндийн төвийн барилга барих /Баян өмжүүл сум/	2019-2021	1,000,000	450,000.0
5	75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих /Алтанбулаг сум/	2019-2020	779,807	500,000.0
<b>ШИЛЖИХ БАРИЛГА ДҮН</b>				
<b>2. ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:</b>			4,674,384.9	2,607,521.4
1	Аймгийн нэгдсэн эмнэлэгт утгалгын байрны барилга барих	2020	180,000.0	180,000.0
2	Хүндэний уялгатай айл орхийн 10/ 0.4 кв -ын ЦДАШ барих,0.4 кв-ын эрчим хүчний шугам, сүлжээний өргөтгөл шинэтгэл хийх	2020	90,000.0	90,000.0
3	Аймгийн хэмжээнд 26 суманд бэлтгэсний худал шинээр гаргах ажлыг	2020	312,000.0	312,000.0
<b>ШИНЭ БАРИЛГИЙН ДҮН</b>				
<b>3. ИХ ЗАСВАР:</b>			582,000.0	582,000.0
1	Содлын төвийн их засвар /Зуулмод/	2020	288,000.0	288,000.0
2	Сумдын орон нутгийн гүүр, хоолойн засвар /Монголморьт, Замнар, Эрдэнэ, Дэлгэрхаан /	2020	160,000.0	160,000.0
<b>ИХ ЗАСВАРЫН ДҮН</b>				
<b>4. ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ:</b>			448,000.0	448,000.0
1	Аймгийн байр нийлэмж зардал	2020	50,000.0	50,000.0

МННГЭН ТӨСӨЛ

2	Зөрөн сумдад шуудангийн үйлчилгээг хэвнй явуулахад зориулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх Баянцгаань, Бүрэн, Дэлгэрхаан, Балцогт, Аргалант, Өндөрширээт, Сүмбэр, Баянчандмань	2020	8,000.0	8,000.0
3	ЕБС, ишгэрлэг, хотуур байрны армун цэврийн байгууламжийг бусад хөрөнгө оруулагч нартай хамтран байгуулахад орон нутгийн оролцоо / Балцогт, Өндөрширээт, Дэлгэрхаан, Цэрл /	2020	140,000.0	140,000.0
4	МСУТ өвгүүдийн лабораторинийн кабинетуудыг шинэчлэх төсөл хэрэгжүүлэх / Заамар, Зуунмод, Баянчандмань, Эрдэнэ /	2020	80,000.0	80,000.0
5	Аймгийн Нийтийн номын сангийн барилгын их зэсварын ажлын орон нутгийн оролцоо	2020	1,196,000.0	276,000.0
6	ЭМТ өвнийг илэрвэх байгууламжтай болгоход дэмжлэг үзүүлэх орон нутгийн оролцооны хөрөнгө / Угтаалцайдан сум /	2020	18,540.8	18,540.8
7	Авто вокзалын төвийн гадна тохиожилтын талбайн ус зайлуулах далавгийн ажлыг олон шийтгэлийн оролцоотой хийх /Аймгийн гол, Зуунмод сум/	2020	25,000.0	25,000.0
<b>ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ДҮН</b>				
<b>5.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ:</b>				
1	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт хяналтын монитор худалдан авах зардал	2020	120,000.0	120,000.0
2	Яаралтай тусламжийн зууцлагын автомашины худалдан авах зардал / Аймгийн нэгдсэн эмнэлэг /	2020	35,000.0	35,000.0
3	Хотны автомашины шинэчлэх зардал / Зуунмод, Хот тохиожуулах /	2020	40,000.0	40,000.0
4	Аймгийн нэгдсэн эмнэлэгт унтуулгын аппарат, томог төхөөрөмж худалдан авах зардал	2020	80,000.0	80,000.0
<b>ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ДҮН</b>			275,000.00	275,000.00
<b>НИЙТ ДҮН</b>			7,496,925.70	4,510,062.20



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
 2019 оны 12 дугаар сарын 05-ны  
 өдрийн 15 дугаар хуралааны 02 дугаар  
 тогтоолын 3 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАМЫН САЛГИЙН ХӨРӨНГӨӨР 2020 ОНД ХИЙГЛЭХ  
 АЖЛУУДЫН ЖАГСЛАЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Төсөвт өртөг	МАНГАН ТӨГРӨГ	
				2020 онд санхүүжүүлэх	2020 онд санхүүжүүлэх
1	Зуунмод хотын хотхонуудын зам талбайн тохижилт	2020	255,000.00	255,000.00	255,000.00
2	Усны аж ахуйн хэсгийн авто замын засвар Зуунмод 5-р баг	2020	80,000.00	80,000.00	80,000.00
3	Орон нутгийн чанартай авто замуудыг тэмдэгжүүлэх зардал	2020	50,000.00	50,000.00	50,000.00
4	Зуунмод хотын хатуу хучилттай авто замын засварын ажил	2020	50,000.00	50,000.00	50,000.00
5	Зуунмод сумын авто замын өвөл зуны арчлалтын ажлын зардал	2020	45,000.00	45,000.00	45,000.00
6	Зуунмод сумын төрийн хатуу хучилттай авто замын өдөр тутмын арчлалтын зардал	2020	35,000.00	35,000.00	35,000.00
7	Авто замын арчлалтын ажил / Борнуур, Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр, Алтанбулаг, Эрдэнэсант, Баянчандмань, Баян, Эрдэнэ сум /	2020	40,000.00	40,000.00	40,000.00
8	Байгалийн болзошгүй гамшиг, шас зудны үед орон нутгийн зам, давааг арчлах, сэргээн засварлах зардал	2020	40,000.00	40,000.00	40,000.00
9	Аймгийн төв доторх хотхонуудын зам талбайн тохижилтын зураг төсөл боловсруулах ажил	2020	13,000.00	13,000.00	13,000.00
10	Орон нутгийн чанартай авто замын хурвэмж төлөврүүдэх зардал	2020	3,000.00	3,000.00	3,000.00
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>611,000.00</b>	<b>611,000.00</b>	<b>611,000.00</b>

Аймгийн өргөдлийн Телевизийн Хурлын  
 00/9 оны 12 дугаар сарын 08 ны  
 өдрийн 15 дугаар хуралдааны 02 дугаар  
 тогтоолын 4 дүгээр хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
 2020 ОНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн
1	Булаг шандны эхийг тохижуулах / 20 сум /	40,000.0
2	Рашаан усыг судалгаа шинжилгээнд хамруулах / 12 рашаан /	5,000.0
3	Сумын төлийн усны усыг цэвэршүүлэх тохоромж суурингуулах / Баяндэлгэр, Баянхалгай, Зуунмод, Лүн, Сүмбэр /	50,000.0
4	Ус түгээж сангуудыг засварлах, шинэчлэх, шинэ карттай болгоно. / Аргалзыт, Архуст, Баян, Баян-Өнжүүл, Борнуур, Заамар, Өндөрширээт, Угтвалцайдам /	70,000.0
5	Лүн суман дахь сум дундын ойн ангид хармууцуулах, Зуунмод суманд хийгдэх "Ногоон паспорт -Ногоон төмөр" ойн зурвасыг өргөжүүлж, 1100 ширхэг навчит мод, гоёлын бут сөөг тарих	23,000.0
6	Ерөнхий агуур зохион байгуулалтын судалгааг хийлгэж, 2021-2025 оны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах.	20,000.0
7	Туул,Хэрлэн голуудын дагуу загас үржүүлэх, жимсний модны бут сөөг тарих үржүүлгийн газар байгуулах төслийн ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ажил	28,300.0
8	Сумдад бэлчээрийн хувааг гаргах 13 сум / Алтанбулаг, Дэлгэрхаан, Бүрэн, Эрдэнэсант, Баян, Баянцагаан, Архуст, Баяндэлгэр, Баянжархалаш, Сэргэлэн,Лүн,Өнхөрширээт, Баян өнжүүл /	156,000.0
9	Тал хэрмийн зарим сумыг цөлжилттэй тэмцэх чиглэлээр загвар сум болгож, хөрсний доройтлыг бууруулах, үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрийн олон наст ургамал тариалах ажлыг зохион байгуулна. / Баянцагаан сум 40 га /	48,000.0
10	Хөндөгдсөн эхлүгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэн, эснэгүй орхигдсон талбайгавс 10 га-д техникийн болон биологийн нэхэн сэргээлт хийх	73,600.0
11	Байгаль орчин, ус, аялал жуулчлалын чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, бодлого хөтөлбөртүүдийн хүрээнд хяналт шалгалт, гүйцэтгэлийн хяналт хүлээн авах ажлыг зохион байгуулна. / 26 сум /	20,000.0
12	Байгаль орчин салбарын албан хаагчдыг чадавхжуулах нэгдсэн сургалт, семинар зохион байгуулах	14,200.0

чингийн төгрөг

13	Усны тооллого судалгаа хийж, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулах	10,000.0
14	Цөлжилтийг сэвэрүүлэх ажлын хүртэнд бэлчээрийн хортонтой тэмцэх ажлыг тал хээрийн сумдын 50.0 мянган га-д зохион байгуулах	100,000.0
15	Харья, Ерөө голын сав газрын зөвлөлийн галдугаар хуралдсаныг зохион байгуулах	10,000.0
16	Сумдын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах / Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баян, Алтанбулаг, Зуунмод /	30,000.0
17	Хогийн уялдуур байгуулах зурал төсөл	10,000.0
18	Ойн хортон мэрэгчтэй тэмцэх ажил	20,000.0
19	Цаг агаарт зориулаар мориолох үйл ажиллагааны зардал	15,000.0
<b>НИЙТ ДУН</b>		<b>743,100.0</b>



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
 2019 оны 12 дугаар сарын 26-ны  
 өдрийн 16 дугаар хуралдааны 02 дугаар  
 тогтоолын 5 дугаар хавсралт

**ТӨСВИЙН ШИЛЖИХ ҮЛДЭГДЛИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР 2020 ОНД ХИЙГЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,  
 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСЛАЛТ**

Мянган  
 Төгрөг

Д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чалал байршил	Эхэлх дугаар хугацаа	Төсөвт өртөг	2020 онд салуурлах дүн
<b>1. ШИЛЖИХ БАРИЛГА:</b>				
1	Одоот хөтлийн орчны зам, талбайн тохижилт	2019-2020	231,687.0	131,687.0
2	Атарчдлын талбай орчмын тохижилтын ажлал	2019-2020	200,000.0	200,000.0
3	Одоот хөтлийн цахилгааны ажлал	2020	15,000.0	15,000.0
4	Одоот хөтлийн нэмэлт ажлал	2020	11,334.1	11,334.1
5	Дулааны станцын 2-р хэлхээний гадна шугам, сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг, төсөв	2019-2020	149,837.2	126,437.2
<b>ШИЛЖИХ БАРИЛГА ДҮН</b>				
<b>2. ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:</b>				
1	ЗДТГ-ын барилга шинээр барих / Бурж сум /	2020-2021	970,000.0	500,000.0
2	Дулааны станцын II-р хэлхээний гадна шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн ажлал / Аймгийн төв, Зууныод /	2020	527,541.7	527,541.7
3	Зууныод Ламс бөгийн чиглэлийн 2.5 км асгалын барилгын ажлал хэлүүлэх	2020	353,678.6	353,678.6
4	Нэгдсэн эмнэлгийн орчмын авто замы, талбайн тохижилтын ажлал	2020	380,000.0	380,000.0
5	Зууныод хотын нийтийн утасныны орон сууцнуудын барилгын ажлын их засвар / 18, 42, 44, 1 - р байр /	2020	200,000.0	200,000.0
<b>ШИНЭ БАРИЛГЫН ДҮН</b>				
<b>3. ИХ ЗАСВАР:</b>				
1	Аймгийн цагдаагийн газрын зүүнжүүлэх салуулах байрны өргөтгөл, их засвар	2020	60,000.0	60,000.0
2	Үерийн далайгийн засварын ажлал хэлүүлэх / Жаргалант сум /	2020	60,000.0	60,000.0
3	Автозамын их засвар хийх / Борнуур сум /	2020	60,000.0	60,000.0
4	Хүмүүн багц сургуулийн гадна талбайд авто зогсоол байгуулж, тохижилт хийх / Зууныод сум /	2020	60,000.0	60,000.0
<b>ИХ ЗАСВАРЫН ДҮН</b>				
			240,000.0	240,000.0

**4.ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ:**

1	Түрээсийн орон сууц хөлөөгөөр хэрэгжүүлэх зардал	2020	400,000.0	400,000.0
2	МОН төслийн эзлэлийг эргэн төлөлт	2020	160,000.0	160,000.0
3	Төрийн үйлчилгээний Хур систем нэвтрүүлэх	2020	250,000.0	250,000.0
